



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цагааннуур тосгоны Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2022/105/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас:70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг:jenisbekh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Д.Назгүл Утас:99427301 Цахим хаяг: nazguld@audit.gov.mn</p> <p>Уужим Алтай Аудит ХХК-ны аудитор: Х.Айгерим Утас:94911004 Цахим хаяг: aykonkh1005@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал, дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3.Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл,нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа.....	17
4.2 Төлбөрийн акт.....	17
4.3 Албан шаардлага	17
4.4 Зөвлөмж	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсонүгийнжагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1. Аудитын санал, дүгнэлт


**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

ЦАГААННУУР ТОСГОНЫ ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
А.РАХИМАН ТАНАА

2022.02.25 № 234
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагааннуур тосгоны Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагааннуур тосгоны Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Данс -ны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>15,833,322.98</u>	<u>38,711,891.10</u>
33	АВЛАГА	3,378,217.78	15,000,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,378,217.78	-
335	Бусад авлага	-	15,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	-	15,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	12,455,105.20	23,711,891.10
354	Хангамжийн материал	12,455,105.20	23,711,891.10
35410	Бичиг хэргийн материал	2,178,200.00	2,178,200.00
35420	Аж ахуйн материал	6,033,372.00	14,533,372.00
35440	Түлш, шатах тослох материал	557,905.10	157,877.10
35460	Хүнсний материал	616,885.10	3,773,699.00
35470	Бусад хангамжийн материал	3,068,743.00	3,068,743.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>749,121,266.14</u>	<u>711,579,875.68</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	749,121,266.14	711,579,875.68
392	Биет хөрөнгө	745,415,266.14	707,873,875.68
39201	Барилга, байгууламж, орон сууц	827,053,389.00	827,053,389.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(92,174,900.10)	(129,682,055.86)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	15,826,937.67	14,799,426.67
39206	Хуримтлагдсан элэгдэл	(9,884,758.55)	(8,070,932.83)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,786,523.00	12,463,310.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,044,477.88)	(10,541,814.30)
39214	Бусад үндсэн хөрөнгө	12,566,989.00	1,950,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(12,566,989.00)	(1,950,000.00)
39217	Ном	1,852,553.00	1,852,553.00
393	Биет бус хөрөнгө	3,706,000.00	3,706,000.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(550,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	3,706,000.00	3,706,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>764,954,589.12</u>	<u>750,291,766.78</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>764,954,589.12</u>	<u>750,291,766.78</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	764,954,589.12	750,291,766.78
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	56,242,726.00	56,242,726.00
51101	Өмч: - төрийн	56,242,726.00	56,242,726.00
512	Хуримтлагдсан үр дүн	(30,818,709.40)	(45,481,531.74)
51210	Өмнөх үеийн үр дүн	(30,818,709.40)	(30,818,709.40)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(14,662,822.34)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	739,530,572.52	739,530,572.52
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>764,954,589.12</u>	<u>750,291,766.78</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	285,780,200.00	301,806,943.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	8,500,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	8,500,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	8,500,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	8,500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	285,780,200.00	293,306,943.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	278,476,700.00	284,532,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	278,476,700.00	284,532,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	205,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	205,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	7,303,500.00	8,569,143.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	7,303,500.00	8,569,143.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	329,906,433.33	316,469,765.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	329,906,433.33	316,469,765.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	326,208,793.33	309,463,265.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	225,150,911.00	216,861,972.62
210101	Үндсэн цалин	221,301,804.00	200,680,272.62
210104	Урамшуулал	3,849,107.00	16,181,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,538,017.22	28,926,545.46
210201	Тэтгэврийн даатгал	28,538,017.22	20,352,045.46
210202	Тэтгэмжийн даатгал	-	2,143,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	1,714,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	428,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	4,287,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,197,896.00	8,879,171.00
210301	Гэрэл, цахилгаан	563,500.00	588,471.00
210302	Түлш, халаалт	6,134,396.00	7,981,000.00
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	309,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,570,000.00	2,187,409.70
210401	Бичиг хэрэг	418,600.00	223,200.00
210402	Тээвэр, шатахуун	749,700.00	419,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	375,000.00	470,000.00
210404	Ном, хэвлэл	50,200.00	50,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	205,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	976,500.00	820,009.70
2105	Нормативт зардал	19,215,375.95	10,472,876.10
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	139,500.00	44,600.00
210502	Хоол, хүнс	18,552,675.95	10,065,576.10
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	523,200.00	362,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	200,000.00
210604	Урсгал засвар	-	200,000.00
2107	Томлолт, зочны зардал	83,700.00	223,200.00
210702	Дотоод албан томилолт	83,700.00	223,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	300,000.00	333,700.00

Цагааннуур тосгоны Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	83,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,152,893.16	41,378,390.46
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,825,854.00	803,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	41,327,039.16	40,574,890.46
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,697,640.00	7,006,500.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	3,697,640.00	7,006,500.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(44,126,233.33)	(14,662,822.34)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(44,126,233.33)	(14,662,822.34)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	52,536,726.00	16,519,032.00	11,290,588.29	80,346,346.29
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	52,536,726.00	16,519,032.00	11,290,588.29	80,346,346.29
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн			-4,708,599.37	-4,708,599.37
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	56,242,726.00	739,530,572.52	-30,818,709.40	764,954,589.12
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	56,242,726.00	739,530,572.52	-30,818,709.40	764,954,589.12
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	56,242,726.00	739,530,572.52	-30,818,709.40	764,954,589.12
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-14,662,822.34	-14,662,822.34
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	56,242,726.00	739,530,572.52	-45,481,531.74	222,689,004.60

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>285,780,200.00</u>	<u>293,306,943.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	285,780,200.00	293,306,943.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	278,476,700.00	284,532,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	278,476,700.00	284,532,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	205,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		205,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	7,303,500.00	8,569,143.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	7,303,500.00	8,569,143.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>285,780,200.00</u>	<u>290,273,443.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	285,780,200.00	290,273,443.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	282,082,560.00	283,266,943.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	227,545,900.00	213,462,400.00
210101	Үндсэн цалин	208,778,262.00	197,280,700.00
210104	Урамшуулал	18,767,638.00	16,181,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,324,500.00	28,938,900.00
210201	Тэтгэврийн даатгал	21,339,700.00	20,364,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,246,200.00	2,143,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,796,900.00	1,714,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	449,300.00	428,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,492,400.00	4,287,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,303,500.00	8,369,143.00
210301	Гэрэл, цахилгаан	563,500.00	953,443.00
210302	Түлш, халаалт	6,240,000.00	6,501,000.00
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	914,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,569,900.00	2,159,900.00
210401	Бичиг хэрэг	418,500.00	223,200.00
210402	Тээвэр, шатахуун	749,700.00	416,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	375,000.00	470,000.00
210404	Ном, хэвлэл	50,200.00	50,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		205,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	976,500.00	795,200.00
2105	Нормативт зардал	12,908,660.00	13,776,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	139,500.00	44,600.00
210502	Хоол, хүнс	12,245,960.00	13,368,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	523,200.00	362,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	15,200,000.00

Цагааннуур тосгоны Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл		15,000,000.00
210604	Урсгал засвар		200,000.00
2107	Томилолт, зочны зардал	83,700.00	223,200.00
210702	Дотоод албан томилолт	83,700.00	223,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	300,000.00	333,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		83,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,046,400.00	803,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,046,400.00	803,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,697,640.00	7,006,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,697,640.00	7,006,500.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,697,640.00	7,006,500.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>-</u>	<u>3,033,500.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	3,033,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	3,033,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	3,033,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		3,033,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-</u>	<u>(3,033,500.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>-</u>	<u>-</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	294,797,300.00	286,095,443.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	294,797,300.00	286,095,443.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	294,797,300.00	286,095,443.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	213,462,400.00	213,462,400.00
210101	Үндсэн цалин	197,280,700.00	197,280,700.00
210104	Урамшуулал	16,181,700.00	16,181,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,938,900.00	28,938,900.00
210201	Тэтгэврийн даатгал	20,364,400.00	20,364,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,143,600.00	2,143,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,714,900.00	1,714,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	428,700.00	428,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,287,300.00	4,287,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,064,500.00	8,369,143.00
210301	Гэрэл, цахилгаан	1,063,500.00	953,443.00
210302	Түлш, халаалт	6,501,000.00	6,501,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,500,000.00	914,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,954,900.00	1,954,900.00
210401	Бичиг хэрэг	223,200.00	223,200.00
210402	Тээвэр, шагахуун	416,300.00	416,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	470,000.00	470,000.00
210404	Ном, хэвлэл	50,200.00	50,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	795,200.00	795,200.00
2105	Нормативт зардал	20,782,700.00	13,776,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	44,600.00	44,600.00
210502	Хоол, хүнс	20,375,400.00	13,368,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	362,700.00	362,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,200,000.00	15,200,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,000,000.00	15,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	223,200.00	223,200.00
210702	Дотоод албан томилолт	223,200.00	223,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	333,700.00	333,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	83,700.00	83,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,837,000.00	3,837,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,837,000.00	3,837,000.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	294,797,300.00	286,095,443.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	284,532,800.00	277,526,300.00

131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	284,532,800.00	277,526,300.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	10,264,500.00	8,569,143.00
132001	Орон нутгийн төсвөөс	10,264,500.00	8,569,143.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	22.00	22.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	13.00	13.00
620003	Үйлчлэх ажилтан	8.00	8.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	19.00	22.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	14.00	14.00
650005	ШҮ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	5.00	8.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	205,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	205,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	205,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	205,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		205,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	205,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	205,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		205,000.00

3.Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цагааннуур тосгоны Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор Х.Айгерим гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Д.Назгүл, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Цагааннуур тосгоны Хүүхдийн цэцэрлэгийн 2021оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго нь сургуулийн өмнөх насны хүүхдэд цогц хүмүүжил сургалт явуулах, тэдний авьяас чадварыг нээн илрүүлж, насанд хүрэгчдийн дэмжлэгтэйгээр бие даасан байдлыг хангах боломжийг бүрдүүлэхэд оршино.

Цэцэрлэгийн сургалтын хөтөлбөрийг цэцэрлэгийн түвшинд хэрэгжүүлэх, хүүхдийн нас хөгжлийн онцлогт нийцсэн сургалт үйл ажиллагаа явуулах, бага насны хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах үйл ажиллагаанд багш, эцэг эх асран хамгаалагчдын оролцоог нэмэгдүүлэх зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн Төсвийн ерөнхийлөгчийн дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тус албанаас тайлант онд Цагааннуур тосгоны Хүүхдийн цэцэрлэгт санхүүгийн баримтад шалгалт хийгдээгүй байна.

Цэцэрлэг нь дотоод хяналтын нэгжтэй ба эрхлэгчийн тушаалаар батлагдсан журам, зааврын дагуу төлөвлөгөөт дотоод хяналтыг хэрэгжүүлдэг байна. Тус цэцэрлэгийн

дотоод хяналтын талаар ойлголт олж авснаар аудитад туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагааннуур тосгоны Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 289.3 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 3.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Цагааннуур тосгоны Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14.6 сая төгрөгөөр буюу 1.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	3 378.2	15 000.0	11 621.8
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	12 455.1	23 711.9	11 256.8
Үндсэн хөрөнгө	749 121.3	711 579.9	-37 541.4
Нийт хөрөнгө	764 954.6	750 291.8	-14 662.8
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	764 954.6	750 291.8	-14 662.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	764 954.6	750 291.8	-14 662.8

Мөнгөн хөрөнгө, урьдчилгаа данс оны эхэнд болон эцэст үлдэгдэлгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 15.0 сая төгрөг болж 11.6 сая төгрөгөөр өссөн нь оны эцэст бусад тооцооны авлага үүсгэснээс шалтгаалжээ. Аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/1075 дугаартай захирамжаар сургууль, цэцэрлэгүүдийн төсвийн хэмнэлтээс төсөвт хийсэн зохицуулалтаар “Багшийн хөгжлийн танхим” ажиллуулахад зориулж тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдан авахад “Ернур” ХХК-нд гэрээний дагуу 15.0 сая төгрөгийг шилжүүлж, авлага үүсгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 23.7 сая төгрөг болж 11.3 сая төгрөгөөр өссөн нь 8.5 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээж авсан болон 3.8 сая төгрөгөөр хүнсний материалын дансны үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Төсвийн хөрөнгөөр 20.5 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 17.7 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 711.6 сая төгрөг болж 37.5 сая төгрөгөөр буурсан нь 3.0 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 133 дугаар тогтоолоор 23.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн акталж данснаас хасаж, үндсэн хөрөнгөнд 40.6 сая төгрөгийн элэгдэл байгуулснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 14.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 14.6 сая төгрөг гарсантай холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 301.8 сая төгрөг болж өмнөх оноос 16.0 сая төгрөгөөр буюу 5.6 хувиар өссөн дүнтэй байна. Өмнөх оноос материаллаг өөрчлөлт гарсан урсгал санхүүжилтийн орлого байна.

Нийт зардал 316.5 сая төгрөг болж өмнөх оноос 13.4 сая төгрөгөөр буюу 4.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, урамшуулал, норматив зардал, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлэг зэрэг зардлууд байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Цагааннуур тосгоны Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны анх батлагдсан төсөв 294.1 сая төгрөг, тодотгосон төсөв 294.8 сая төгрөг байна.

Тодотгосон төсөв нь анх батлагдсан төсвөөсөө 0.6 сая төгрөгөөр өссөн дүнтэй байна. Үүнд: Цалингийн зардлыг 1.2 сая, нийгмийн даатгалын шимтгэлийг 0.3 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 3.0 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 15.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, нормативт зардлыг 16.8 сая, байр ашиглалттай холбоотой зардлыг 2.0 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

Ковид-19 өвчний улмаас 2021 онд сургууль, цэцэрлэгүүдийн үйл ажиллагаанд тогтоогдсон хязгаарлалтын улмаас тус цэцэрлэгийн хоолны зардал төлөвлөснөөс хэмнэлттэй гарах байсан ба тайлант хугацаанд хоолны зардлаас 7.0 сая төгрөгийг хэмнэж, төсөвт төвлөрүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхэд 294.8 сая төгрөгийн төсөв батлагдсан байна. Нийт зарлагын 284.5 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 10.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 284.5 сая, орон нутгийн төсвөөс 8.6 сая, нийт 293.1 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 286.1 сая төгрөгийг зарцуулж, төсөвт 7.0 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Орон нутгийн төсвөөс 1.7 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 286.1 сая төгрөг буюу 97.0 хувьтай байна.

Нийт төсвийн 74.6 хувийг цалин, 10.1 хувийг НДШ-ийн зардал, 2.9 хувийг тогтмол зардал, 0.7 хувийг хангамж бараа материалын зардал, 4.8 хувийг норматив зардал, 5.3 хувийг эд хогшил, урсгал засварын зардал, 1.3 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 0.3 хувийг бусад зардал тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны байгууллагаас 0.2 сая төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч, уг санхүүжилтийг хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Цагааннуур тосгоны Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаатай холбоотой онцолсон асуудал байхгүй.

Цагааннуур тосгоны Хүүхдийн цэцэрлэг нь тайлант онд гүйцэтгэлээр 293.1 сая төгрөгийг зарцуулсан ба 269.3 сая төгрөг нь байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой зардал бөгөөд үлдсэн 23.8 сая төгрөг нь тэвчиж болох зардал бөгөөд Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1-д заасны дагуу тэвчиж болох 23.8 сая төгрөгийн зардлын 10 хувь буюу 2.4 сая төгрөгийн хэмнэлтийг гаргаж ажиллаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Цагааннуур тосгоны Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайланд нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цагааннуур тосгоны Хүүхдийн цэцэрлэг нь 2021 онд шилэн дансанд оруулбал зохих нийт 151 мэдээллийн 139 мэдээллийг хугацаандаа оруулсан, 2 мэдээллийн оруулах хугацаа болоогүй ба 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Тус байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- ✓ Таван сая төгрөгөөс дээш нийт худалдан авалтын 5.4 сая төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй.
- ✓ Авлага үүсгэсэн талаарх 15.0 сая төгрөгийн 1 шийдвэрийг оруулаагүй.
- ✓ Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш 15.0 сая төгрөгийн зарлагын гүйлгээг мэдээлээгүй.
- ✓ 5 сая төгрөгөөс дээш цалингийн зардлаас бусад орлогын 23 мэдээллийн 22-ыг хугацаандаа оруулж, 1 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Хугацаандаа мэдээлсэн боловч тайлант оны 4 дүгээр сараас бусад бүх саруудын 251.4 сая төгрөгийн санхүүжилтийн дүнг хоосон мэдээлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын дүнгээр 286.8 сая төгрөгийн албан шаардлагыг өглөө.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар хугацаанд оруулбал зохих 10 мэдээллийг хугацаа хоцроож, санхүүжилт, төсөв, хөрөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн шийдвэр, аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний дүнг байршуулаагүй зөрчилд зөвлөмж, цалингийн зардлын төсвөөс 3.4 сая төгрөгийн нийгмийн даатгалд илүү шилжүүлж авлагатай үүсгэсэн, хоолны зардлаас 1.5 сая төгрөгийг зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулсан, 61.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалын хөрөнгийн тооллого хийгдээгүй зөрчилд албан шаардлага өгч, ажилчдад 1.2 сая төгрөгийн гарт олгох цалинг илүү олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

Тус цэцэрлэгийн 2021 оны 04 тоот албан бичгээр зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актын биелэлтийг ирүүлсэн байна. Давтан шалгаж үзэхэд төлбөрийн актыг барагдуулж, авлага үүсгэсэн, хөрөнгийн тооллоготой холбоотой зөрчлүүдийг арилгасан боловч шилэн данстай холбоотой зөрчлүүд арилаагүй байна.

Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагын мөрөөр хийсэн ажлын тайланг шилэн дансанд байршуулаагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар тус Хүүхдийн цэцэрлэгийн ажил, гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл, зардлын дансны бичилт, нярвын бараа материалын тайлангийн бүрдүүлэлт болон төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа материалын зарцуулалтад хяналт тавих, эд хөрөнгийн тооллогын тооцоо бодолтод анхаарах, төсвийн хэмнэлтийг төсөвт буцаан төвлөрүүлсэн эсэхийг хянах шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 295.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 289.2 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлж, 6.1 сая төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд залруулсан алдаа байхгүй.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт байхгүй.

4.3 Албан шаардлага

Аудитаар нийт 289,2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Цагааннуур тосгоны Хүүхдийн цэцэрлэг нь тайлант онд гүйцэтгэлээр 293.1 сая төгрөгийг зарцуулсан ба 269.3 сая төгрөг нь байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой зардал бөгөөд үлдсэн 23.8 сая төгрөг нь тэвчиж болох зардал бөгөөд Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1-д заасны дагуу тэвчиж болох 23.8 сая төгрөгийн зардлын 10 хувь буюу 2.4 сая төгрөгийн хэмнэлтийг гаргаж ажиллаагүй байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7, 10.1.11-д заасныг үндэслэн гаргасан “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тэвчиж болох зардлаас хэмнэж зарцуулаагүй 2.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

2. Шилэн дансанд санхүүжилтийн 251.4 сая төгрөгийн 22 мэдээллийг 0 дүнтэйгээр мэдээлсэн, 1 сарын мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5.4 сая төгрөгийн зарлагын мэдээллийг огт мэдээлээгүй, 15.0 сая төгрөгийн авлага үүсгэсэн тухай шийдвэрийг мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагын 15.0 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй зэргээр нийт **286.8** сая төгрөгийн зөрчил гаргасан байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн дундаж хувь 63.8 хувьтай байна. Өмнөх аудитаар шилэн данстай холбоотой зөвлөмж өгөгдсөн зөрчлүүдийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 4.1.3-д “хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх”, 6.1-д “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж мэдээллийг бүрэн байршуулах талаар албан шаардлага өгөгдлөө.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн анхан шатны баримтын бүрдүүлэлт, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Анхан шатны бүрдэл дутуу баримтаар 4.7 сая төгрөгийн ажил гүйлгээг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн, санхүүгийн тайлангаарх бараа материалын үлдэгдлийг няравын бараа материалын тайлангийн үлдэгдэлтэй тулгахад 1.4 сая төгрөгийн зөрүү гарсан, бараа материалын тайлангийн зарлагын гүйлгээний анхан шатны баримтуудыг дутуу бүрдүүлсэн, зардлын нотлох баримтууд хангалтгүй байх зэрэг нийт 6.1 сая төгрөгийн зөрчил гаргасан байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.3.2, 14.3.3, 14.4, 14.4.1 14.4, 14.4.5, 20.1.1, 20.1.3, 20.1.4, 20.2, 20.2.5, 20.2.6 дахь заалтуудыг мөрдөж худалдан авсан бараа материалыг шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлийг арилгах, санхүүгийн анхан шатны баримтын бүрдүүлэлтийг хангаж ажиллах, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг бэлтгэх аргачлал, зааврыг мөрдөж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ногооннуур сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг	2	295.3					2	289.2	1	6.1